



ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2026 оны 07 сарын 24 өдөр

Дугаар 98

Улаанбаатар хот

Тусгай зөвшөөрөл хүчингүй болгох тухай

Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 6.2 дугаар зүйлийн 1.2 дахь хэсэг, 8.1 дүгээр зүйлийн 9.4, 9.8, 9.12 дахь заалт, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 15 дугаар зүйлийн 15.1.1 дэх заалт, Радио долгионы тухай хуулийн 5¹ дүгээр зүйлийн 5¹.1.8 дахь заалт, 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэг, 18 дугаар зүйлийн 18.1.2 дахь заалт, Шуудангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалт, 10¹ дүгээр зүйлийн 10¹.2 дахь хэсэг, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд зөрчлөө арилгаагүй хавсралтад дурдсан хуулийн этгээд (12)-ийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болсонд тооцсугай.

2.Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон шийдвэрийг тусгай зөвшөөрөл эзэмшигч болон хуулийн этгээдийн харьяалах татварын албанд мэдэгдэх, холбогдох өөрчлөлтийг мэдээллийн нэгдсэн санд оруулах арга хэмжээ авахыг Захиргааны удирдлага, хамтын ажиллагааны газар /З.Эрдэнэчулуун/-т, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус хорооны дарга /Ж.Бат-Эрдэнэ/-д тус тус даалгасугай.

3.Энэхүү шийдвэрийг эс зөвшөөрвөл хуульд заасан хугацаанд шүүхэд гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

ДАРГА

Ж.БАТ-ЭРДЭНЭ

ГИШҮҮД

Б.АНХБААТАР

Ц.ГАНЗОРИГ

Б.ДАГВАСҮМБЭРЭЛ

Ч.ЗОЛБАЯР

С.ТАМИР

А.ҮЙЛСТӨГӨЛДӨР

Харилцаа холбооны зохицуулах хорооны
2026 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн
98 тоот тогтоолын
хавсралт

Тусгай зөвшөөрөл хүчингүй болгосон хуулийн этгээдийн
жагсаалт

№	Хуулийн этгээдийн нэр	Тусгай зөвшөөрлийн дугаар	Хамрах хүрээ, Тусгай зөвшөөрөл, Үйлчилгээний хүртээмж
1	“Бүрэн цэнгэл” ХХК	12100479	Монгол Улсын нутаг дэвсгэрт Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэх
2	“Глобал телеком инженеринг” ХХК	12100684	Монгол Улсын нутаг дэвсгэрт Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэх
3	“Комтех Солюшн ХХК	13600130	Өмнөговь аймгийн нутаг дэвсгэрт Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэх /Интернэтийн үйлчилгээ/
4	“Наники” ХХК	13600125	Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэх /Интернэтийн үйлчилгээ/
5	“Нүрзад нетворкс” ХХК	13600108	Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэх /Интернэтийн үйлчилгээ/
6	“Саплай” ХХК	12100681	Монгол Улсын нутаг дэвсгэрт Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэх
7	“Тайван говь” ХХК	12100752	Монгол Улсын нутаг дэвсгэрт Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэх
8	“Эйр спэйс монгол” ХХК икс	13600148	Монгол Улсын нутаг дэвсгэрт Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэх /Интернэтийн үйлчилгээ/
9	“Эйр спэйс монгол” ХХК икс	23700051	Улаанбаатар болон 21 аймгийн нутаг дэвсгэрт Радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах
10	“Эйр спэйс монгол” ХХК икс	23700052	Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт Радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах
11	“Энхнуга” ХХК	13600166	Завхан аймгийн нутаг дэвсгэрт Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэх /Интернэтийн үйлчилгээ/

12	“Эс эс эн ай эс эм” ХХК	12100757	Монгол Улсын нутаг дэвсгэрт Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэх
----	----------------------------	----------	---

----- оОо -----